

ТАЛХЫГ АДИСЛАХ НЬ

Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь,
үүнээс хүртэх тэд бүгдийн бодгалийн тулд;
тэд түүний Сүнсийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгаж болохын тулд
таны Хүүгийн биеийг төлөөлөн дурсаж,
тэд үүнийг идэж, Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь,
тэд өөрсөдөдөө таны Хүүгийн нэрийг авч мөн үргэлж түүнийг санаж,
мөн өөрсөд нь өгсөн түүний зарлигуудыг дагахад
бэлэн гэдгээ танд гэрчилж болохын тулд,
энэ талхыг адисалж мөн ариулахыг таны Хүү Есүс Христийн
нэрээр бид танаас гуйж байна.
Амен.

УСЫГ АДИСЛАХ НЬ

Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь,
үүнээс уух тэд бүгдийн бодгалийн тулд,
тэд түүний Сүнсийг өөрсөдтэйгөө хамт байлгаж болохын тулд,
өөрсдийнх төлөө асгаруулсан таны Хүүгийн цусыг төлөөлөн дурсаж,
тэд үүнийг үйлдэж болохын тулд; Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь,
тэд үргэлж түүнийг санана гэдгээ танд гэрчилж болохын тулд,
энэ усыг адисалж мөн ариулахыг таны Хүү Есүс Христийн
нэрээр бид танаас гуйж байна.
Амен.